



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Журмуудыг батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын “Бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай” А/121 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 5.1.8 дах хэсэг, “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмын 2.2, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмыг нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Албан хэрэг хөтлөлтийн журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Энэхүү журмуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах талаар сургалт зохион байгуулахыг Захиргаа, санхүү, төлөвлөлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн /Б.Алтан-Очир/-д үүрэг болгосугай.

3. Тушаал батлагдсантай холбогдуулан “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргын 2014 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/02 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /А.Нямхүү/-д даалгасугай.

ДАРГА  М.ГОНЧИГЖАВ



3150600032